



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/218

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдсэн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ийн хүрээнд 3, 4 дүгээр сард зарцуулах зардалд зориулан 9 999 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 9 999 000 төгрөг /есөн сая есөн зуун ерэн есөн мянга/-ийг аймгийн Байгаль хамгаалах сангийн 1.1-д тусгагдсан арга хэмжээнээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д тус тус зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж зам гаргах ажил”-ын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жарогалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
05 дугаар сарын 06-ны өдрийн
А/218 дугаар захирамжийн хавсралт



“ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГТ ХОГ ОТВОЛДОЖ ДАРЖ
ЗАМ ГАРГАХ АЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /60 хоног/	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1.	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	3600	1900	6 840 000
2.	Тос, масло	багц	1	709 000	709 000
3.	Сэлбэг, хэрэгсэл	багц	1	2 000 000	2 000 000
4.	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	60	5000	300 000
5.	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	60	2500	150 000
	Нийт				9 999 000

-oOo-